



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн банкны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, хоёр удаагийн нээлттэй дуудлага худалдаагаар оролцогч ирээгүй нийт 347,844,707.00 (гурван зуун дөчин долоон сая найман зуун дөчин дөрвөн мянга долоон зуун долоон) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 9 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Төрийн банкны гүйцэтгэх захирал Ө.Гантөрд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын болон орон нутгийн өмчийн газрын төлөөллийг оролцуулан дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2023 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн
 7.1... дугаар тогтоолын хавсралт



Төрийн банкны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нээлттэй дуудлагын
 худалдаагаар дахин худалдах автомашин

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	2019 оны 352, 2022 оны 498 дугаар тогтоолоор тогтоосон үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоож худалдах доод үнэ (төгрөг)
1	Марк-2, 92-77 ТӨА, арал № GX1100006937	2002/ 2002	10,500,000.00	1,500,000.00	900,000.00
2	BMW-730Li, 10-22 УНУ, арал № WBAHN21000DS91 846	2006/ 2007	35,000,000.00	17,800,000.00	10,680,000.00
3	Ниссан Патрол 94- 59 /70-08/дго /убв/	2007/ 2007	63,449,772.00	10,000,000.00	6,000,000.00
4	Уаз 315142-012 21- 71өмө	2010/ 2010	18,500,000.00	3,500,000.00	2,100,000.00
5	форд эверест 99- 00 /70-84/бөү /унэ/	2011/ 2011	49,950,000.00	5,500,000.00	3,300,000.00
6	форд эверест 99- 60унө	2012/ 2012	52,081,645.00	5,500,000.00	3,300,000.00
7	Хьюндай Террекан 25-09унн	2003/ 2003	14,200,000.00	4,500,000.00	3,150,000.00
8	форд эверест 54- 46 /37-96/гаү /унө/	2012/ 2012	52,081,645.00	5,500,000.00	3,300,000.00
9	форд эверест 54- 37 /98-64/сзү /унө/	2012/ 2012	52,081,645.00	5,500,000.00	3,300,000.00
	Нийт дүн		347,844,707.00 (гурван зуун дөчин долоон сая найман зуун дөчин дөрвөн мянга долоон зуун долоон)	59,300,000.00 (тавин есөн сая гурван зуун мянга)	36,030,000.00 (гучин зургаан сая гучин мянга)